



Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны төлөвлөгөөнд нийт 7 дотоод аудит гүйцэтгэхээр тусгагдсан. Төлөвлөсөн дотоод аудитыг хийж гүйцэтгэхээс гадна яамны удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус 2 аудит, **нийт 9 дотоод аудитыг гүйцэтгэсэн.**

Төлөвлөгөөт дотоод аудит:

“Дулааны
цахилгаан
станц-4” ТӨХК

“ДБЭХС”
ТӨХК

“Улаанбаатар
дулааны сүлжээ”
ТӨХК

Сайдын багцын 2017
оны төсвийн урсгал
зарлагын төлөвлөлт,
гүйцэтгэл

“БНДС”
ТӨХК

“УБЦТС” ТӨХК

Гадаадын зээл, тусламжийн
хөрөнгөөр хэрэгжиж буй
төслүүдийн 2017 оны
санхүүгийн үйл ажиллагаа

Төлөвлөгөөт бус дотоод аудит:

“Хөвсгөл ДС”
ТӨХК

Эрчим хүчний сайдын
эрхлэх асуудлын
хүрээний үйлдвэрийн
газар, ТӨХК-иудын
Шилэн дансны тухай
хуулийн хэрэгжилт



2017 онд гүйцэтгэсэн 9 дотоод аудитын үр дүнд нийт 111 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Дотоод аудитыг гүйцэтгэх явцад гарч байгаа нийтлэг зөрчлүүд:

1. Төрийн өмчит хувьцаат компаниудийн үйл ажиллагааны зардалд тавих хяналт хангалтгүйгээс үр ашиггүй зарцуулалт ихсэж байна
2. Өр, авлагын зохистой харьцаа алдагдаж, хяналт хэрэгжүүлээгүйгээс өр авлага нэмэгдэж байна
3. Худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлж зохион байгуулдаггүй, хэрэгцээ шаардлагад үндэслэн оновчтой, бодитой төлөвлөөгүй, тэдгээрт тавих дотоод хяналт хангалтгүй байна
4. Компанийн орон тоо, бүтцийн хувьд оновчтой зохион байгуулах, салбаруудын орон тооны давхардлыг арилгаагүй зэрэгт салбарын хэмжээнд анхаарч ажиллах шаардлагатай байна.
5. Нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтийг буруу хийх
6. Хяналт, шалгалтын зорилго, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гол анхаарлыг төвлөрүүлэх чиг хандлагыг хэвшүүлэхэд дотоод аудитын гүйцэтгэх үүргийг зохих түвшинд хүргэж хөгжүүлэх шаардлагатай байна.
7. Дотоод хяналтын орчинд гүйцэтгэх удирдлагын баримталж буй байр суурь, мэдлэг чадвар шууд нөлөөлдөг тул гүйцэтгэх удирдлагууд дотоод хяналтын системийн талаар ойлгож дотоод хяналтын орчныг бүрдүүлэх, дотоод аудиторуудын чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байна.



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР

САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, МӨН “ХЯЗГААРЛАЛТТАЙ” ДҮГНЭЛТ АВСАН 8 БАЙГУУЛЛАГЫН ЗӨВЛӨМЖ, АКТ, АЛБАН ШААРДЛАГУУДЫН БИЕЛЭЛТИЙГ ХАНГУУЛАХ ХҮРЭЭНД АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангаар зөвлөмжийн биелэлт 82 хувь, акт албан шаардлагын биелэлт 88 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар зөвлөмжийн биелэлтийг 100 хувь биелүүлэх тал дээр хяналт тавин ажиллаж байна.

№	Байгууллагын нэр	Биелэлт /хувь/
1	“ДҮТ”ХХК	80%
2	“ДЦС-4” ТӨХК	81%
3	“ӨБЦТС” ТӨХК	98%
4	“Дулаан шарын гол” ТӨХК	78%
5	СЭХҮТ	45%
6	“Даланзадгад ДЦС” ТӨХК	98%
7	“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК	100%
8	“Ховд Дулааны станц” ТӨХК	75%

Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

“Хязгаарлалттай” дүгнэлт авсан 8 байгууллагаас 7 байгууллагын Гүйцэтгэх захирал, 2 байгууллагын Ерөнхий нягтлан бодогч ажлаасаа чөлөөлөгдөж /ДЦС-4, СЭХҮТ/, 3 байгууллагын Ерөнхий нягтлан бодогчид албан тушаал бууруулах /ДДС/, сахилгын шийтгэл /ДҮТ, Ховдын ДС/ ногдуулсан байна. /ДзДЦС ТӨХК, ӨБЦТС ТӨХК, Дулаан Шарын гол ТӨХК нь холбогдох албан тушаалтнууд арга хэмжээ аваагүй байна/ Цаашид гадаад болон дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх, акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах тал дээр анхаарч ажиллах талаарх зөвлөмжийг өгсөн.